

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ-д

Нэхэмжлэл гаргах нь:

Улаанбаатар

Нэхэмжлэгч: Оршин суугаа газрын хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар

Нэхэмжлэлийн шаардлага: Эрх зүйн чадамжгүйд тооцуулж, асран хамгаалагчаар тогтоолгох тухай

Миний төрсөн дүү В.Д нь 1987 оны 8 дугаар сарын 2-ны өдөр төрсөн, одоо 33 настай. В.Д нь хөгжлийн бэрхшээлтэй төрсөн бөгөөд энэ өвчин хүндэрсээр оюуны хомсдол, шинж тэмдгийн уналт таталт сэтгэцийн эмгэг өвчтэй оношоор 100 хувь хөдөлмөрийн чадваргүй нь тогтоогдсон бөгөөд эдгэрэх хугацаагүй болно. В.Д нь сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй, хэвтрийн дэглэмд байдаг бөгөөд хоол идэх, хувцас өмсөх, бие засах гэх мэт үйлдлийг ч хүний тусламжгүйгээр хийж чаддаггүй. Түүнийг бидний ээж Н.С өөрийн асрамжинд байлгаж, харж халамжилж байгаад 2019 оны 8 дугаар сарын 22-ны өдөр нас барсан. Хууль ёсны асран хамгаалагч нь нас барсан тул төрсөн эгч болох В.Н миний бие өөрийн асрамжинд авах хүсэлтийг Баянгол дүүргийн Цагдаагийн газар гаргахад шүүхээр эрх зүйн чадамжгүйд тооцуулж, асран хамгаалагчаар тогтоолгох шаардлагатай гэдэг хариу өгсөн.

Иймд В.Д-г иргэний эрх зүйн чадамжгүйд тооцож, төрсөн эгч В.Н намайг асран хамгаалагчаар нь тогтоож өгнө үү.

Нэхэмжлэлд хавсаргасан баримтууд:

- 1.Нэхэмжлэл 1 хувь /1 хуудас/ эх хувь
- 2.Миний иргэний үнэмлэхийн хуулбар нотариатчаар гэрчүүлсэн /1 хуудас/
- 3.Миний оршин суугаа хорооны Засаг даргын тодорхойлолт /1 хуудас/ эх хувь
- 4.Дүү В.Д-н иргэний үнэмлэхийн нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар /1 хуудас/
- 5.В.Д-г 100 хувийн хөдөлмөрийн чадвар алдалтайг тогтоосон Эмнэлэг, хөдөлмөр магадлалын комиссын дүгнэлт /1 хуудас/ нотариатчаар гэрчлүүлсэн
- 6.В.Д-г оюуны хомсдол, шинж тэмдгийн уналт таталт сэтгэцийн эмгэг өвчтэйг тогтоосон Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн шинжээчийн дүгнэлт /2 хуудас/ нотариатчаар гэрчлүүлсэн
- 6.В.Д-н нийгмийн халамжийн тэтгэвэрийн дэвтрийн нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар /2 хуудас/
- 7.Улсын тэмдэгтийн хураамж 70.200 төгрөг төлсөн баримт, эх хувь нийт 10 хуудас

Улсын тэмдэгтийн хураамжийг Татварын ерөнхий газрын itax.mta.mn сайтаас төлбөрийн даалгавар үүсгэж, дурын банкны салбарт тушаах эсхүл шүүхийн байранд байршуулсан Geregе системийн өөртөө үйлчлэх төхөөрөмжөөр банкны карт ашиглан төлөх боломжтой.



Нэр

Нэхэмжлэл гаргасан:

... гарын үсэг ... гарын үсгийн тайлал